



АГААР ХӨРГӨГЧ АЕ-Н5

/AIR COOLER/

АШИГЛАЛТЫН ЗААВАР



Энэхүү бүтээгдэхүүнийг хэрэглэхийн өмнө ашиглалтын заавартай сайтар танилцана уу.

ТАНИЛЦУУЛГА:

Энэхүү агаар хөргөгч нь агаар хөргөх болон халаах зориулалттайгаар сүүлийн үеийн дэвшилтэт технологийн дагуу тусгайлан үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн болно.

Бидний мэдэх эйр кондишн нь хөргөх шингэн-фреоны тусламжтайгаар хүйтэн/мөсөн хана үүсгэж халуун агаарыг нэвтрүүлэх замаар агаарыг сэрүүцүүлдэг бол агаар хөргөгч /air cooler/ нь усан хана үүсгэн халуун агаарыг нэвтрүүлж агаарыг хөргөдөг.

Тус бүтээгдэхүүнийг зөвхөн зуны халуун өдрүүдэд ашиглах бус хүйтэн сэрүүний улиралд халаах горимд нь шилжүүлж, эрчим хүчний хэмнэлттэй, хурдан хугацаанд халаах керамик халаагуур (2000w) болгон ашиглаж болно.

Хуурай, хагас хуурай уур амьсгалын бүсэд орших манай улсын нөхцөлд ус ууршуулан сэрүүцүүлэх технологи бүхий уг агаар хөргөгч төхөөрөмж нь нэн тохиромжтой ба зөвхөн агаарыг хөргөх бус чийгшүүлж, ионжуулан ариутгаж эрүүл, ая тухай ажиллах амьдрах таатай орчинг бүрдүүлнэ. Бүтээгдэхүүний сэрүүцүүлэх чадал, үр нөлөөг дээшлүүлэхийн тулд цонхоо онгойлгож агаарыг чөлөөт урсгалыг дэмжихийн сацуу усны саванд мөс, ус хийж ажиллуулвал зохилтой.

ИОНЖУУЛАГЧ:

Агаар хөргөгч төхөөрөмж нь агаарыг хөргөж, халаахаас гадна ионжуулдаг. Ер нь бидний агаарт эерэг, сөрөг цэнэгт ион зэрэгцэн оршдог. Эерэг ион нь нүүрстөрөгчийн давхар ислийн молекулын нэгдэл бол сөрөг ион нь хүчилтөрөгчийн молекул юм.

Төхөөрөмжөөс сөрөг цэнэгт ион ялгаруулснаар агаарт тогтох нүүрстөрөгчийн давхар исэл бүхий тоос, тоосонцор, нян бактери, утааны элементийг татаж цэвэрлэхээс гадна биежүүлж гадаргуу дээр унагаах онцгой чадвартай. Үүний үр дүнд агаар дахь хүчилтөрөгчийн урсгал нэмэгдэж, чөлөөтэй амьсгалах, тархины цусан хангамж сайжрах нөлөөллийг үзүүлж, дархлааг дэмжин бүтээмжийг дээшлүүлдэг.

Энэхүү ионжуулагч нь хүний биед сөрөг нөлөөлөлгүй тул байнга ажиллуулж болно.

ТЕХНИКИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Хүчдэл	220V
Давтамж	50Hz
Чадал	2000W
Усны савны хэмжээ	12L




Унтраалга: Бүтээгдэхүүний ар талд байрлах ба цахилгааныг доорхи товчоор асааж унтраана.





АГААР ХӨРГӨГЧИЙН АЖИЛЛАГАА:

Агаар хөргөгчийг ажилуулахдаа бүтээгдэхүүний арын дээд хэсэгт байрлах шилжүүлгийг "Cooling" хэсэгт тохируулна.

Агаар хөргөгчийг ажиллагаанд бэлтгэх



1. Агаар хөргөгчийг хайрцагнаас нь дагалдах хэрэгслүүдийн хамт гаргана. Үндсэн төхөөрөмжийг тэгш гадаргуу дээр байршуулна.
2. Дугуйг угсрах: 4 дугуйг агаар хөргөгчийн суурийн дугуй орох нүхний ойролцоо тавина. Зогсоогчтой 2 дугуйг төхөөрөмжийн хойд талд байрлуулах бол энгийн 2 дугуйг нь урд талд нь байрлуулна. Суурийн нүхэнд дугуйнуудыг хийнэ. (Fig.-1)
3. Усны саванд ус хийх: Усны савны түгжээг хэвтээ чиглэлд эргүүлнэ. (Fig.-2) Усны савыг гарган авч саванд цэвэр ус хийнэ. Усны түвшин нь усны савны "MAX" түвшинээс хэтрэхгүйгээр хийгдэнэ. (Fig.3-4)



Агаар хөргөгчийн ажиллагаа

Төхөөрөмжийн цахилгааны утсыг залгуурт залгана. Төхөөрөмжийн ар талд байрлах улаан товчлуурын асаах хэсгийг дарна. LED дэлгэц нь автоматаар өрөөний агаарын температурыг заах ба ажиллахад бэлэн төлөвт төхөөрөмж шилжинэ. Төхөөрөмжийн ажиллагаа нь дэлгэц дээрх товчлуур болон алсын удирдлагаар удирдагдана.

1. **On/Off:** Удирдлагын дэлгэцийн “On” товчлуур, алсын удирдлагын On/Off товчлуур дээр дарахад төхөөрөмж хурдны завсрын түвшинд шилжинэ. Хэдэн минутын дараа сэнсны хурд дэлгэцэн дээр үзэгдэх, эсвэл өмнө санах ойд хийгдсэн сэнсний хурдын түвшинд очино. Буцаагаад төхөөрөмжийг унтраахын тулд дэлгэцний “Off” товчлуур, алсын удирдлагын “On/Off” товчин дээр дарна.
2. **Speed:** Сэнсний хурдын их, дунд бага хурдны түвшингээс сонголт хийхэд энэ товчийг дарна. “Speed” товчин дээр дарах бүрд дэлгэцэн дээр одоогийн хурдны түвшинг үзүүлнэ.
3. **Wind:** Салхилах хэв маяг, урсгалыг сонгохдоо “Wind” товчийг дарна. Дэлгэцэн дээр сонгосон салхины төлөвийг үзүүлнэ.
Normal: Үргэжилсэн салхины үлээлт үүсгэх ба их, дунд, бага хурдаар тохируулагдана.
Natural: Зөөлөн, ая тухтай орчинг үүсгэх ба их, дунд, бага хурдаар тохируулагдана.
Sleep: Унтлагын горим нь сэнсний хурдны түвшингээс хамаарч ажиллана. Сэнсний хурд өндөр түвшинд унтлагын горим дээр тавихад хурд их, дунд, бага, түр унтрах гэсэн зарчмаар ээлжлэн 30 минут ажиллаад, автоматаар хурдны дунд түвшинд шилжинэ. Хурдны дунд түвшинд унтлагын горим нь сэнсний хурд дунд, бага, түр унтрах гэсэн горимоор ажиллах бол хурдны бага түвшинд хурд бага, түр унтрах гэсэн зарчмаар ажиллана.
4. **Timer:** “Timer” товчыг дарснаар сэнсний ажиллагаанд зориулсан 1-12 цагийн тохиргоо хийгдэнэ. Сонгосон цаг нь дэлгэцэнд харагдах ба цаг дуустал асна. Хүссэн цагаа тохируулахын тулд товчин дээр тасралтгүй дарна. Цагаа цуцлахын хүсвэл тохиргоог “00” болтол дарна.
5. **Swing:** “Swing” товч нь сэнсний салхилах чиглэлийг өөрчлөхөд зориулагдсан. Товчны гэрлэн тэмдэглэл нь уг функц идэвхитэй байх үед


асна. Товчин дээр ахин дарахад салхины чиглэлийн хөдөлгөөн зогсоно. Агаарын урсгалын босоо чиглэлийг тохируулахдаа агаар гарах салхивчны хөндлөн хаалтыг гараараа дээш доош болгоно.

6. **Cool:** Энэхүү товчийг дарснаар агаар хөргөгч /air cooler/-ийн үндсэн функц ажиллаж эхэлнэ. Ус шахагч насос нь усны савнаас ус татан авч хөргөх хавтан руу дээрээс асгана. Хөргөх хавтан нь хүйтэн усыг өөртөө шингээн авна. Сэнсээр үлээгдсэн гадна халуун агаар хөргөх хавтанг нэвтрэхдээ халуунаа алдаж, чийглэг сэрүүн агаар гаргана. Агаар хөргөгчөөс гарсан хүйтэн агаар нь дотор агаарын хэмийг багасгаж, сэрүүн тухтай орчинг үүсгэнэ. Үр нөлөөг нь нэмэгдүүлэхийн тулд усны саванд мөс хийж болно.

Анхаарах: Хэрэв усны саван дахь усны түвшин бага, эсвэл ус байхгүй үед “Cooler ” функцийг ажиллуулахгүй байвал зохино. Усны түвшинг шалгаж, шаардлагатай бол ус нэмэх, усны саван дахь усаа багадаа 7 хоногт нэг удаа асгаж, шинэчлэх хэрэгтэй.

ХАЛААГУУРЫН АЖИЛЛАГАА:

Халаагуурыг ажиллуулахдаа бүтээгдэхүүний арын дээд хэсэгт байрлах шилжүүлгийг "Heating" хэсэгт шилжүүлнэ. Халаах функц ажиллах үед сэнсний хурд тогтмол "Middle" буюу дунд хурд дээр тохируулагдсан байх бөгөөд өөр хурдны түвшин сонгогдохгүй.



7. **Heat/Wind:** Дэлгэцэн дээр байх тус товчийг дарснаар халаалгуур ажиллана. Нэг дарахад бага халаалт (1000w), хоёр дарахад их халаалт 2000(w), ахин дарахад халаах функц идэвхигүй болно. Энэхүү төхөөрөмж нь хэт халуунаас хамгаалагч термостаттай, керамик халаагууртай юм. Халаагуурын функцний найдвартай, хэвийн үйл ажиллагааг хангахын тулд халаалтыг зогсоохдоо дэлгэцийн “Off” товчлуур дээр дарж унтрааж, багадаа 30 секунд хөргөж амраасны дараа дараагийн үйлдлээ хийнэ.
8. **Ionizer :** “Ion” товчин дээр дарснаар ионжуулагч функц идэвхижнэ. Дэлгэцэн дээрх гэрэл нь сөрөг цэнэгт ион ялгаруулж байгааг илтгэнэ.

Усны савыг ашиглах

Усны саван дахь усны түвшин “MIN” түвшинээс бага байгаа эсэхийг тогтмол шалгана. Агаар хөргөх “Cool” функцыг ажиллуулж байхад хангалттай бус ус саванд байх нь усны насос бүрэн ус татаж авч чадахгүй байх нөхцлийг үүсгэх ба энэ нь агаар хөргөгч систем эвдрэх, хэвийн бус ажиллах нөхцөл болно. Үйлдвэрлэгчээс усгүй ажилласнаас үүсэх усны насосын гэмтлийг хэрэглэгчийн буруу ажиллагаанаас үүссэн гэж үзэн үйлдвэрийн баталгаат засварт хамааруулдаггүй болно.

Цахилгааны залгуураас салгаж, төхөөрөмжийн ар талд байх үндсэн унтраалгын “Off” байрлалд шилжүүлж, бүрэн унтраасны дараа усны саванд ус хийнэ.

Мөсны савыг ашиглах:

Агаар хөргөгчийн үр дүнг нэмэгдүүлэхийн тулд төхөөрөмжтэй цуг ирэх мөсний савыг ашиглах нь зохимжтой. Хэрэглэхийн өмнө эдгээрийг хэдэн цаг хөлдөөгчинд хийнэ. Дараа нь усны савны том хэсэгт байрлуулах ба усаа “MAX” түвшин хүртэл хийж дүүргэнэ. Мөсний савыг ашигласнаар илүү хүйтнээр үлээж, агаар хөргөлтийг дэмжих болно.

Аюулгүй ажиллагааны зааварчилгаа

1. Ажилуулахаас өмнө цахилгааны утас болон төхөөрөмжинд гадна эвдрэл гэмтэл байгаа эсэхийг шалгана.
2. Усны савыг авахаас өмнө цахилгааны утсыг залгуураар нь салгасан байна.
3. Төхөөрөмжийн агаар орох, гарах хэсэг рүү гадны аливаа биет хийхийг хориглоно.
4. Төхөөрөмжийг ямар нэг зүйлээр бүтээсний дараа ажиллуулж болохгүй. Энэ нь хэт халалт үүсгэж шаталт, мотор гэмтэх эрсдэл үүсгэнэ.
5. Агаар хөргөгчийг хэрэглээгүй үед, мөн зөөх, угсрах, цэвэрлэх үед цахилгааны утсыг залгуураар нь салгасан байна.
6. Усны саванд ямар нэг химийн бодис, хатуу биет хийхийг хориглоно.
7. Төхөөрөмжийн үйл ажиллагааны заавартай танилцаагүй хүн ажиллуулахыг оролдож болохгүй.
8. Гадуур асгарсан устай орчинд агаар хөргөгчийг ажиллуулж болохгүй. Цахилгааны богино холболт үүсэх, галын аюултай.
9. Борлуулагчийн засвараас өөр газарт төхөөрөмжийг засах, задлахыг

оролдсон нөхцөлд үйлдвэрийн баталгаат засвар үйлчилгээнд хамрагдахгүй байх нөхцөл үүснэ.

10. Удаан хугацаанд шууд нарны тусгал дор төхөөрөмжийг байрлуулахаас зайлсхийнэ.
11. Агаар хөргөгчийг ажиллуулахын өмнө усны саванд хангалттай ус байгаа эсэхийг тогтмол шалгана. 14 хоног бүр усны саван дахь усыг бүрэн шинэчилж, цэвэр ус хийнэ.

Цэвэрлэгээ үйлчилгээ

Тодорхой хугацааны дараа агаар дахь тоос, тоосонцор нь төхөөрөмжийн тоосны шүүлтүүр, хөргөх хавтанд шигдэж, агаар хөргөгчийн хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж эхэлдэг бөгөөд иймд эдгээр шүүлтүүр, хөргөх торыг тогтмол цэвэрлэж байхыг зөвлөдөг. Цэвэрлэгээг хийхийн өмнө төхөөрөмжийг цахилгааны утсаар нь залгуураас салгаж, бүрэн унтраасан байна.

1. Тоосны шүүлтүүр /филтер/

Ар талын тоосны шүүлтүүрийг авахдаа гарын хуруугаараа түгжээн дээр нь дарж, татаж авна. Хүч сул цэвэрлэгээний бодис ашиглаж, зөөлөн сойз, арчигчаар шүүлтүүрийн тоос, бохирдлыг цэвэрлэнэ. Дуусаны дараа шүүлтүүрийн доод хэсгийг хийгээд, дараа нь дээд хэсгийг түлхэж анхны байрлалд оруулна.

2. Хөргөх хавтан /тор/

Тоосны шүүлтүүрийг авсны дараа цаад талд нь хөргөх хавтан харагдана. Хөргөх хавтаны дунд хэсэгт байх түгжээн дээр дараад зөөлхөн татаж авна. Цэвэр алчуур, эсвэл зөөлөн сойзоор хавтан дээр байх тоос, шороог цэвэрлэнэ. Шаардлагатай бол цэвэр усанд булхуулж, агаарт хатаана. Хавтанг цэвэрлэхдээ ямар нэг химийн бодис хэрэглэж огт болохгүй.

Агаар хөргөгч нь усны савны жижиг хэсгээс насосны тусламжаар ус татан авч хөргөлтийн хавтан лүү юүлдэг. Зөгийн үүр хэлбэрийн хөргөлтийн хавтангаар ус дамжин урсаж, буцаад усны савны том хэсэг руу ордог. Энэхүү байнгын эргэлдэх явцын үр дүнд хавтанд үлдсэн тоос, бохирдол доошоо усны сав руу унах ба савны дунд байрлах шүүлтүүр бохирдлыг тунгаадаг.